

Гарчиг

1. Танилцуулга	2
1.1. ICDL Азийн танилцуулга	2
1.2. ICDL хөтөлбөрийн танилцуулга	2
1.2.1. ICDL Анхан шатны модуль	2
1.2.2. ICDL Стандарт шатны модуль	2
1.2.3. ICDL Ахисан шатны модуль.....	3
1.2.4. ICDL Захиалгат модуль /custom profile/	3
2. АЁШТ-ийн дотоод ажилчдын үүрэг.....	3
2.1. Төвийн менежер.....	3
2.2. Итгэмжлэгдсэн хянагч багш	3
2.3. Сургагч багш.....	3
3. Бүртгэл.....	4
3.1. Шалгалтанд бүртгүүлэх шаардлага	4
3.2. Шинээр шалгалтанд бүртгүүлэх	4
3.3. Шалгуулагчийн бүртгэлийн дугаар	6
4. Шалгалтын үйл ажиллагаа.....	6
4.1. Шалгалтын өдөр анхаарах зүйлс.....	6
4.2. Шалгалт эхлэхээс өмнө анхаарах зүйлс.....	6
4.3. Шалгалтын үеэр анхаарах зүйлс	6
4.4. Шалгалтын хариу.....	6
5. Гэрчилгээ	7
6. Шалгалтын дүрэм, зохион байгуулалт.....	7
7. Санал хүсэлт	7
7.1. Саналт хүсэлт	7
7.2. “Тусгай орчин”-ы шаардлага, хүсэлт.....	8

ICDL Азийн Албан ёсны шалгалтын төвийн гарын авлага

1. Танилцуулга

1.1. ICDL Азийн танилцуулга

“Олон улсын компьютерийн хэрэглээний гэрчилгээ” олгох (ICDL) шалгалт нь олон улсын стандартын шалгуур үзүүлэлтэнд суурилсан хэрэглэгчдийн компьютерийн хэрэглээний ур чадвар, мэдлэг, практикийг үнэлдэг шалгалт юм.

Анх 1995 онд “Европийн компьютерийн хэрэглээний гэрчилгээ” буюу ECDL хөтөлбөрийн санаа бий болж 1997 онд ECDL Сан байгуулагдсан. Уг шалгалт европ төдийгүй олон улсын хэмжээнд хэрэгцээ шаардлага нь өсч шалгалтанд хамрагдагсдын хүрээ улам бүр тэлж тив дамжсан байна. Ийнхүү үйл ажиллагааны шаардлагаар 1999 онд “Олон улсын компьютерийн хэрэглээний гэрчилгээ” ба ICDL хөтөлбөрийг танилцуулсан. Өнөөдөр ICDL нь ECDL-ийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд нэрийн хувьд зарчмын ялгаа байхгүй, нэгэн ижил хөтөлбөр хэрэгжүүлдэг бөгөөд 24000 шалгалтын төвөөр дамжин 150 улс орны 41 хэлний 13 сая гаруй хүнд хүрч чадсан.

“Олон улсын компьютерийн хэрэглээний гэрчилгээ”-ний шалгалт “Анхан”, “Дунд”, “Ахисан” шатны гурван модультай. ICDL модуль бүр хамгийн сүүлийн үеийн мэдээллийн технологийн ур чадвар, мэдлэгийг практиктай хослуулсан агуулгыг хөтөлбөртөө тусгадаг байна. Модулийн түвшин тус бүрт гэрчилгээ олгодог давуу талтай тул хүссэн хүн бүр шалгалтанд оролцох боломжтой.

1.2. ICDL хөтөлбөрийн танилцуулга

1.2.1. ICDL Анхан шатны модуль

ICDL-ийн Анхан шатны модуль нь МХХТ-ийн өдөр тутмын хэрэглээнд зайлшгүй шаардлагатай үндсэн чадвар юм.

1.2.2. ICDL Стандарт шатны модуль

Стандарт шатны модуль нь анхан шатны модуль дээр суурилдаж таны өдөр тутмын мэдлэг, ажлын байрны хэрэглээнд шаардсан ур чадваруудыг хөгжүүлэхэд боломж өгдөг.

1.2.3. ICDL Ахисан шатны модуль

ICDL Ахисан шатны модуль нь шаардлагатай ICDL-ийн чадварын түвшинд хүрсэн, цаашид компьютерийн чадвараа дээшлүүлэх хүсэлтэй хүмүүст зориулсан өндөр шатны хөтөлбөр юм. ICDL Ахисан шатны модуль нь хамгийн их хэрэглэгддэг дөрвөн компьютер програмаар мэргэжлийн түвшинд ажиллаж чадах ур чадварыг олгож баталгаажуулдаг.

1.2.4. ICDL Захиалгат модуль /custom profile/

Шалгуулагч нь модулиудыг хольж шалгалт өгөн ICDL захиалгат модулийн гэрчилгээ авах боломжтой. Энэ нь өөрийн шаардлагатай болон хүссэн чиглэлээр ICDL шалгалт өгөх боломж бүрддэг.

2. АЁШТ-ийн дотоод ажилчдын үүрэг

2.1. Төвийн менежер

ICDL-ийн хөтөлбөртэй холбогдох санал хүсэлт, хөтөлбөрт өөрчлөлт шинэчлэл орсон тохиолдолд хамгийн түрүүнд холбоо барих хүн бол АЁШТөвийн менежер юм. Энэ хүн АЁШТ дахь ICDL-ийн хөтөлбөр зохимжтой хэрэгжиж байгааг хянах үүрэгтэй.

2.2. Итгэмжлэгдсэн хянагч багш

Итгэмжлэгдсэн хянагч багш /цаашид ИХБ/ нь шалгалтын явцыг хянах үүрэгтэй. ICDL Ази нь шалгалтыг хянах багш нь сургалтыг хэрэгжүүлсэн багшаас өөр хүн байхыг зөвлөж байна.

ICDL-ийн ИХБ болохын тулд тухайн хүн АЁШТ-ийн Хянагч багшийн анкетийг бөглөж Ёс зүйн дүрмийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан байх ёстой. ИХБ нь ИХБ-ийн гэрчилгээ болон ИХБ-ийн тэмдэг авах бөгөөд энэ нь шалгалтын үеэр ил байх ёстой. АЁШТ нь багадаа 2 ИХБ-ийг санал болгоно.

2.3. Сургагч багш

Сургагч багш нь ICDL-ийн хөтөлбөрийн сургалт явуулах үүрэгтэй. Тухайн заах модулийн чиглэлээр хангалттай мэдлэгтэй ба сургалт зохион байгуулах туршлагатай байх шаардлагатай.

3. Бүртгэл

3.1. Шалгалтын шаардлага

АЁШТ нь шалгуулагчийн хүйс, нас, яс үндэс, иргэншил, шашин, бие бялдрын чадвар, компьютерийн мэдлэгийн түвшин болон өмнө нь тухайн шалгуулагч нь ICDL хөтөлбөрт бүртгүүлж байсан эсэхийг үл хамааран бүх шалгуулагчийг бүртгэнэ.

3.2. Шинээр шалгалтанд бүртгүүлэх


1. ICDL-ийн шалгалтанд хамрагдахын тулд шалгуулагч бүр МТҮП-ийн ICDL-ийн шалгалтын цахим бүртгэлийн хуудас руу орж бүртгүүлэх сонголтыг хийж бүртгүүлнэ. www.itpark.mn/icdl
2. Бүртгүүлсний дараа өгөх шалгалтын сонголт хийж захиалгаа өгнө.
3. Захиалга хийснээс хойш 5 ажлын өдрийн дотор шалгалтын төлбөрийг МТҮП-ийн Голомт банкны дансанд шилжүүлж, төлбөрийн баримтын зургийг шалгалтын захиалгад хавсаргаж захиалгаа баталгаажуулна. **/Голомт банк 110209987/**

itpark.mn/icdl/web/index.php/user/4

ICDL-ийн ШАЛГАЛТЫН ТӨВ

Тусламж ICDL-ийн шалгалтууд Мивий мэдээлэл Нууц үг солих Холбоо барих Гаргах

Хэрэглэгчийн мэдээлэл

 [Зураг солих](#)

Өөрийн нэр	
Эцэггэхийн нэр	
Имейл хаяг	
Хүйс	
Төрсөн огноо	
Регистерийн дугаар	
Холбоо барих утас	
Холбоо барих утас	
Ажил эрхлэлтийн байдал	
Өмчийн хэлбэр	
Идэвхитэй эсэх	
Бүртгүүлсэн огноо	

Шалгалтын захиалга

Санамж

- Шалгалтын захиалга өгснөөс хойш 7 хоногт багтаан төлбөрийг хийх
- Төлбөр хийгдсэн дараа шалгалтын захиалга баталгаажих ба захиалга баталгаажсаны дараа цуцлах боломжгүй

#	Түвшин	Нэр	Төлбөр	Төлөв	Захиалсан огноо	
1	ICDL Анхан шатны модуль	Үзүүлэн бэлтгэх	\$45	Төлбөр хийгдэхийг хүлээж байна.	2015-06-16 16:14:05	Дэлгэрэнгүй Төлбөрийн баримт хуулах Цуцлах

4. ICDL-ийн шалгалт хариуцсан ажилтан төлбөрийн баримтыг шалган баталгаажуулна. /Төлбөрийн баримтыг хүлээж аваагүй бол “Төлбөрийн баримт дахин хуулах” гэсэн сонголт харагдана. Та сонголтыг дарж дахин төлбөрийн баримтаа оруулна уу. Хэрэв баталгаажуулсан болон захиалгын төлөв нь “Төлбөр хийгдсэн” гэж харагдана./

Шалгалтын захиалгын дэлгэрэнгүй мэдээлэл

Санамж

- Шалгалтын захиалга өгснөөс хойш 7 хоногт багтаан төлбөрийг хийх
- Төлбөр хийгдсэний дараа шалгалтын захиалга баталгаажих ба захиалга баталгаажсаны дараа цуцлах боломжгүй

Төлбөрийн баримт дахин хуулах

Шалгалтын нэр	Өгөгдлийн сангийн хэрэглээ
Шалгалтын тухай	<input checked="" type="checkbox"/> Сертификаттай <input checked="" type="checkbox"/> Бэлтгэл шалгалттай
Нэмэлт	<ul style="list-style-type: none">• ICDL Онлайн хичээл - \$10
Захиалагч	Сувд Чинбат
Төлбөр	\$30
Төлбөрийн баримт	Харах
Төлбөрийн баримт хуулсан огноо	2015-06-17 09:23:24
Шалгалтын өдөр	Төлбөр хийгдсэний дараа өдрөө сонгоно.
Төлөв	Төлбөрийн баримт хүчингүй
Захиалсан огноо	2015-06-17 09:23:14

Шалгалтын захиалгын дэлгэрэнгүй мэдээлэл

Санамж

- Шалгалтын захиалга өгснөөс хойш 7 хоногт багтаан төлбөрийг хийх
- Төлбөр хийгдсэний дараа шалгалтын захиалга баталгаажих ба захиалга баталгаажсаны дараа цуцлах боломжгүй

Шалгалтын нэр	Үзүүлэн бэлтгэх
Шалгалтын тухай	<input checked="" type="checkbox"/> Сертификаттай <input checked="" type="checkbox"/> Бэлтгэл шалгалттай
Нэмэлт	
Захиалагч	
Төлбөр	\$45
Төлбөрийн баримт	Харах
Төлбөрийн баримт хуулсан огноо	2015-06-17 09:15:04
Шалгалтын өдөр	Төлбөр хийгдсэний дараа өдрөө сонгоно.
Төлөв	Төлбөр хийгдсэн.
Захиалсан огноо	2015-06-16 16:14:05

5. АЁШТ нь төлбөрийн баримтыг баталгаажуулсаны дараа 14 хонгийн дотор таньтай холбоо барьж шалгалт өгөх өдрийг тохирно.

3.3. Шалгуулагчийн бүртгэлийн дугаар

ICDL-ийн хөтөлбөрт бүртгэгдсэн шалгуулагч бүрт 10 оронтой дугаар хуваарилж өгөх бөгөөд энэ дугаараар өөрийн хувийн онлайн шалгалтын системийн хуудсанд хандана. Гэрчилгээний шалгалтанд орохоос өмнө шалгуулагч нь хүчинтэй бүртгэлийн дугаартай байх ёстой.

4. Шалгалтын үйл ажиллагаа

4.1. Шалгалтын өдөр анхаарах зүйлс

- Шалгалт эхлэхээс 45 минутын өмнө АЁШТ дээр ирсэн байх
- Шалгуулагч нь Иргэний үнэмлэхтэй ирэх ёстой.

4.2. Шалгалт эхлэхээс өмнө анхаарах зүйлс

- Шалгуулагч нь шалгалтын өрөөнд орохдоо Иргэний үнэмлэх болон шалгуулагчийн бүртгэлийн дугаараа шалгуулна.
- Хуваарилсан ширээнд сууна.
- Шалгуулагч бүр өөрсдийн хувийн эд зүйлсийг (жнь: цүнх, ном, дэвтэр, гар утас г.м.) хурааж далд хийнэ.
- Шалгалт эхлэхээс 5 минутын өмнө ИХБ шалгуулагч нарт дараах мэдээллийг мэдээллэнэ:
 - шалгалтын системд нэвтрэх
 - шалгалтын үргэлжлэх хугацаа
 - шалгуулагч нар хоорондоо ярихыг хатуу хориглохыг анхааруулна.

4.3. Шалгалтын үеэр анхаарах зүйлс

- Шалгалтын үеэр ИХБ шалгалтын өрөөнд байна.
- Шалгуулагч нар хоорондоо ярих, нэгнийхээ ажлыг харахыг хатуу хориглоно.
- Шалгалтын хугацааг зогсоож болохгүй.
- Шалгалтын үеэр шалгалтын өрөөнөөс гарч болохгүй.
- Шалгуулагч нь шалгалтын хугацаа дуусахаас өмнө шалгалтаа өгч дууссан бол түрүүлж гарч болно.

Гэрчилгээний шалгалтанд 75%-иас дээш авсан тохиодолд шалгуулагч нь тухайн модулийн шалгалтыг тэнцсэн гэж үзнэ.

4.4. Шалгалтын хариу

- Шалгуулагч шалгалтаа өгч дуусахад шалгалтын хариу дэлгэцэн дээр гарч ирнэ

- Шалгалтын хариуны хуулбарыг АЁШТ нь шалгуулагчдад гаргаж өгнө.
- Хэрэв шалгуулагч тэнцээгүй бол дахин шалгалтын төлбөрөө төлж дараагийн шалгалтанд дахин орж болно.

5. Гэрчилгээ

Шалгуулагч нь модулиудыг хольж шалгалт өгөн ICDL Захиалгат модулийн гэрчилгээ авах боломжтой.

Сар бүрийн эхний 14 хоногийн дотор АЁШТ нь ICDL Азиас гэрчилгээнүүдийг хүлээж авч шалгуулагч нарт гардуулж өгнө.

6. Шалгалтын дүрэм, зохион байгуулалт

Шалгуулагчид хоорондоо ярих, бие биенийхээ ажлыг харсан эсвэл ICDL-ийн шалгалтын журамд зөрчил үүссэн бол АЁШТ-ийн ажилтан, эсвэл ИХБ нь тухайн асуудалд хамааралтай шалгуулагч нарт дараах арга хэмжээ авна:

- Шалгалтыг зогсоож
- Шалгалтын өрөөнөөс чимээгүй гаргана.

Үүний дараа нь АЁШТ нь тухайн шалгуулагчийн мэдээлэл болон түүний Шалгуулагчийн бүртгэлийн дугаарыг болсон үйл явдлын баримттай хамт ICDL Азид илгээнэ.

Мөн АЁШТ нь дараах зүйлсийг хамааралтай шалгуулагч нарт мэдэгдэнэ:

- Тухайн шалгуулагчийн ICDL шалгалт нь “тэнцээгүй”-д тооцогдож
- Тухайн үйл явдлыг гүйцэд шалгаж ICDL Азиас хэрхэн арга хэмжээ авах шийдвэр гарах хүртэл тухайн шалгуулагчийн бүртгэлийн дугаар нь түр хугацаанд хүчингүй болно.

Хэрэв холбогдох шалгуулагч нь гомдол гаргах хүсэлтэй бол тухайн үйл явдал болсоны ажлын 5 өдрийн дотор ICDL Азид (info@icdlasia.org) хандаж болно. ICDL Ази нь ямар нэгэн шийдвэр гаргаж үүнийгээ АЁШТ-ийн менежер болон холбогдох шалгуулагч нарт бичгээр мэдэгдэх бөгөөд гарсан бүх шийдвэр эцсийн байдлаар гарахыг анхаарна уу.

7. Санал хүсэлт

7.1. Саналт хүсэлт

Шалгуулагч нь шалгалтын явцад санал гомдол байвал Төвийн менежерт хандах бөгөөд санал, гомдлыг шийдвэрлэхэд асуудал үүссэн тохиолдолд 5 өдрийн дотор АЁШТ-д мэдүүлж болно.

Санал гомдлыг Тусгайлан гаргасан загварын дагуу ойлгомжтой, бичгээр мэдүүлнэ. АЁШТ-ийн менежер нь хүсэлтийг info@icdlasia.org-хаягаар ICDL Азид илгээнэ. **Загварын энд дарж татна үү.**

Санал гомдлын хариуг АЁШТ-ийн менежер болон шалгуулагч нарт бичгээр өгөх бөгөөд энэ нь эцсийн шийдвэр байна

7.2. “Тусгай орчин”-ы шаардлага, хүсэлт

Шалгуулагчийн хөгжлийн бэрхшээлийг үл хамааран ICDL-ийн гэрчилгээг шалгуулагч бүр авах боломжтой. Хөгжлийн бэрхшээлтэй шалгуулагч нар тусгай хүлээн зөвшөөрөгдсөн орчинд Гэрчилгээг авах боломжтой.

Тусгай орчингийн хүсэлт ирэх тутамд АЁШТ-ийн менежер тусгай орчингийн хүсэлтийн маягтийг тусгай орчинд шаардагдах бүх шаардлагийг нарийн зааж ICDL Азид илгээнэ. ICDL Ази нь тухайн хүсэлтийг хүлээж авах эсэх шийдвэр гаргана.